



lendmn

2022 оны II улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

“ЛэндМН ББСБ” ХК

Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны II улирлын
санхүү, үйл ажиллагааны тайлан

- Зээлийн үйл ажиллагаа ————— 06 Зээлийн үйл ажиллагаа
08 Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд
- Бизнесийн үйл ажиллагаа ————— 10 Бизнесийн үйл ажиллагаа
- Харилцагчийн үйл ажиллагаа ————— 34 Харилцагчийн үйл ажиллагаа
- Санхүүгийн үйл ажиллагаа ————— 36 Санхүүгийн үйл ажиллагаа
37 Санхүүгийн байдлын хураангуй тайлан
38 Орлого, үр дүнгийн хураангуй тайлан
- Эрсдэлийн удирдлага ————— 40 Эрсдэлийн удирдлага
41 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
- Компанийн засаглал ————— 42 Компанийн засаглал
42 Төлөөлөн удирдах зөвлөл
44 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод



**LendMN
аппли케йшний
бүтээгдэхүүн
үйлчилгээний
төрөл
нэмэгдлээ.**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Сайн байцгаана уу,

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид, хамтрагчид, харилцагчид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтан мэндчилж байгаадаа баяртай байна.

ЛэндМН нь хувьцаа эзэмшигчид, харилцагчдынхаа өмнө хариуцлагатай, зохицуулалт өндөртэй, нөгөө талаас томоохон хөрөнгө оруулагч, хувьцаа

эзэмшигчдийн итгэлийг хүлээсэн компани убраас найдвартай төдийгүй хэзээд хөгжлийн түүчээлэгч компани байж ирсний хувьд бүтээгдэхүүн үйлчилгээгээ дараагийн түвшинд гаргахаар тэмүүлж, LendMN аппликеийшний бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ төрлийг нэмэгдүүлэн сайжруулалт хийн ажиллаж байна.

LendMN аппликеийшний “Зээл” цэсээс харилцагчдын хэрэгцээнд зориулсан Lendzээл- Хэрэглээний зээлийн үйлчилгээ, Lendpay-Худалдан авалтын зээлийн үйлчилгээ, Lendauto- Эко автомашины зээлийн үйлчилгээнүүдийг харилцагчдадаа хүргэн ажиллаж байгаа төдийгүй харилцагчдынхаа амьдралын хэв маягт тохирсон тэдний санхүү, хөрөнгө оруулалтын мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх шинэ үйлчилгээнүүдийг багтаасан “Хөрөнгө оруулалт” цэстэй болж, энэхүү цэсээр дамжуулан Lendplus, Lendbond, Lenditгэлцэл зэрэг мөнгөн хөрөнгөө зөв удирдахад чиглэсэн бүтээгдэхүүнүүдээс харилцагч өөрт тохирсон үйлчилгээгээ сонгож өгөөж хүртэх эсхүл тухайн бүтээгдэхүүний мэдээлэл авах, туршиж үзэх, хэрэглээд хэвших, дадал болгох боломжийг бүрдүүлэх зорилгоор зах зээлд нэвтрүүлж эхлээд байна.

Цаашилаад LendMN аппликеишн нь Монголын хамгийн анхны финтек бизнес модель, дижитал зээлийн үйлчилгээний соёлыг нэвтрүүлэгч төдийгүй таны хэрэгцээнд зориулсан санхүүгийн асуудлыг шийдэх, санхүүгээ зөв удирдах Хэзээ ч, Хаана ч дэргэд чинь байх дэвшилтэд технологийн шийдэл хэвээр байсаар байна.

2022 оны хагас жилийн компанийн цэвэр зээлийн багц 27.8%-иар өсөж, компанийн нийт орлого 8.1 тэрбум төгрөг, цэвэр ашиг 1.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь нийт орлого өмнөх оны мөн үеэс 27%-иар өссөн үзүүлэлттэй байгаа нь бидний бизнесийн цар хүрээ өсөн нэмэгдэж буйг илэрхийлэхээр байна.

Бид 2021 оны II-р сарын 29-ний өдөр арилжаалсан “ЛэндБонд” Транч-1-ийн өгөөжийг хөрөнгө оруулагчдийн үнэт цаасны дансанд 2022 оны 05-р сарын 31-ний өдөр байршууллаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж компанийн өөрийн нэрэмжит төгөлтэй болох их үйлсийг эхлүүлж ЛэндМН-ийн залуучууд Чингэлтэй дүүргийн Хайрхан Хөгжлийн Төвд 150 ширхэг мод тарилаа. Энэ нь зөвхөн энэ хаврын ажил төдий бус тогтмол жил бүр мод тарихаар төлөвлөж, үүрэг амлалтаа санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлээд байна. Үгүээр ч зогсохгүй Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын нэрэмжит “Цэцэрлэгт Хүрээлэн”-ийн шав тавих их үйлсэд нэгдэж, ЛэндМН-ийн хамт олноороо Гачуурын Минж үргүүлгийн газарт мод тарилаа.

ЛэндМН нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудыг манлайж ажилладгийн хувьд “Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо”-оос уламжлал болгон зохион байгуулагд “We Care Tomorrow” уриатай “Сагсан Бөмбөгийн Аварга Шалгаруулах 8 Дахь Удаагийн Тэмцээн”-ийг ЛэндМН ББСБ-ын хамт олон амжилттай зохион байгууллаа.

ЛэндМН-ийн хувьд 2022 оны II улиралд олон олон өдөрлөг, арга хэмжээний ивээн тэтгэгч, хамтран зохион байгуулагчаар оролцож, шинэ үйлчилгээгээ танилцуулсан тун завгүй улирал болж өнгөрлөө. Тухайлбал “Mongolian Jewellery & Metal Expo-2022”, “IPO Mongolia 2022 Forum”, “Good Workplace Awards 2022”, “Глобал Боловсролын Форум 2022”, “Авто Машинтай Болоход Амархан” өдөрлөг, “Tech Invest 2022” гэх мэт арга хэмжээнүүдэд амжилттай оролцон бүтээгдэхүүн үйлчилгээгээ таниуulan, зах зээлд нэвтрүүлэн ажилласан байна.

Ингээд ЛэндМН нь нийт харилцагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ 2022 оны II улирлын санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна ■

Хүндэтгэсэн:


“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захидал Б.Удавал

ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА




2022 оны II улиралд нийт харилцагч нартадаа 71.98 тэрбум төгрөгийн дүнтэй 332 мянган зээлийг LendMN аплийшнээр дамжуулан олгосон байна.
Түүнчлэн 2022 оны II улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2022 оны I улиралтай

харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 1.8%, олгосон зээлийн тоо 19.7%, цэвэр зээлийн багц 25.7%-иар тус тус өссен амжилттайгаар бид 2022 оны II улирлаа үдлээ.



2022 оны II улирлын үзүүлэлтүүдийг өмнөх I улиралтай харьцуулсан байдал



Зээлийн үйл ажиллагаа

ЗЭЭЛИЙН БАГЦЫН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 оны II улирлын байдлаар чанаргүй зээлийн тэрбум төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн багцад эзлэх хувь 5.98% байгаа бөгөөд энэ хүрэлцээг өмнөх улиралаас 4.8%-иар нэмэгдүүлж улиралд зээлийн эрсдэлийн сангийн нөөц 3.03 || 14.2% хүргэж ажиллалаа.

Тэрбум төгрөг	2022.I	2022.II
Нийт зээлийн багц	35.50	44.47
Зээлийн эрсдэлийн сан	(2.53)	(3.03)
Цэвэр зээлийн багц	32.97	41.44
Хэвийн зээл	32.13	40.82
Хугацаа хэтэрсэн зээл	1.05	1.00
Чанаргүй зээл	2.32	2.65
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	6.5%	5.98%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	109.1%	14.2%






Бизнесийн үйл ажиллагаа

2022 оны II улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

Бизнесийн үйл ажиллагаа

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцааны ханшийн мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн I ангилаад 17 компанийн 194,406 ширхэг хувьцаа арилжигдсанаас “ЛэндМН ББСБ” ХК-ийн 634 ширхэг хувьцаа арилжигдсан бөгөөд 2022 оны II улирлын хаалтын байдлаар компанийн нэгж хувьцааны ханш 34.99 төгрөгөөр хаагдлаа.

2022 оны II улиралд:

Нийт арилжаалагдсан ширхэг - 1.33 сая ширхэг
Нийт арилжаалагдсан үнийн дүн - 51.01 сая төгрөг

**Хувьцаа
эзэмшигчдийн
эзлэх хувь**





Бизнесийн үйл ажиллагаа

"Mongolian Jewellery & Metal Expo-2022" үнэт эдлэл, үнэт металлын үзэсгэлэнд LendMN-ийн шинэ үйлчилгээ Lendpay-ээр оролцлоо

Монголд анх удаа үнэт металл, үнэт чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, урлагч гоёлчимэглэлийн худалдаа эрхлэгч албан байгуулага иргэдийг нэгтгэсэн үзэсгэлэн худалдаа 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн турван өдөр үргэлжлэн амжилттай зохион байгуулагдаа. Энэхүү Үзэсгэлэнгийн зорилго нь салбарыг нэгдсэн мэдээллээр хангах, бүтээгдэхүүн үйлчилгээг тэр болон олон нийтэд сурталчлан

таниулах, борлуулалтад дэмжлэг үзүүлэх байлаа. Үзэсгэлэн "Үнэт металлын үндэсний холбоо", "Мишээл Экспо" ХХК санаачлан Соёлын яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Стандарт хэмжил зүйн газрын дэмжлэгтэйгээр "Түмэн Эрдэнэс" холбоо, Алт арилжаалагчдын холбоо, "Эвт холбоо" НҮТББ, "Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо", "Planet gold Mongolia" болон "ЛэндМН ББСБ" ХК ивээн тэтгэгчээр



ажилмаж, хамтран зохион байгуулж, амжилттай оролцлоо. Тус үзэсгэлэнгийн үеэр LendMN-ийн шинэ үйлчилгээ Lendpay-г танилцуулж, Lendpay тэмдэглэгээтэй газруудаас урьдчилгаа, шимтгэлгүй шуудаваад хувааж төлөх үйлчилгээгээр алт, мөнгөн ээмэг бөгж, мөнгөн аяга, үнэт эдлэл, алмаазан

шигтгээтэй бөгж зэргийг худалдан авалтын зээлээр авах боломжийг санал болгохын зэрэгцээ LendMN-ийн зээлийн гэрээ байгуулах, зээлийн гэрээ сунгах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийн тухай мэдээлэл өгч амжилттай ажилалаа. #Lendpay #шуудавья #хуваажтэлье



Бизнесийн үйл ажиллагаа

"IPO Mongolia 2022 Forum"-хүртээмжтэй хөрөнгийн зах зээл форумд "ЛэндМН ББСБ" ХК ивээн тэтгэгчээр хамтран оролцлоо

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Шангри-Ла Улаанбаатарт "IPO MONGOLIA-2022" форумыг "Санхүүгийн зохицуулах хороо" болон "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо"-той хамтран зохион байгууллаа. ЛэндМН нь Хөрөнгийн зах зээлд томоохон байр суурь эзэлдэг, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхны IPO гаргасан ББСБ-ын хувьд тус форумын Ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран

ажиллаа.

Энэхүү форумын голмох хэлэлцүүлэг болох "Бондын зах зээлийн хөгжил, зохицуулалтын орчин ба бонд гаргахад анхаарах асуудлууд" сэдвийн хүрээнд ЛэндМН нь олон нийтэд нээлттэй гаргасан Лэндбондын туршлагаа хуваалцан хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаа.

#LendMN #IPOMongolia2022Forum

Бизнесийн үйл ажиллагаа

"Good Workplace Awards 2022" арга

ХЭМЖЭЭНД ЛЭНДМН ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР ХАМТРАН АЖИЛЛАЛАА

Монголд анх удаа зохион байгуулагдаж буй шилдэг ажил олгогч байгуулмагыг тодруулах "Good Workplace Awards 2022" арга хэмжээ Шангри-Ла Улаанбаатарт 2022.5.12-нд болж ЛэндМН-ийн хамт олон "Асаа Шинээр Сэтгэ, Асаа Амжилтаа бүтээ" уриатайгаар ивээн тэтгэгчээр оролцлоо. Тус үйл ажиллагааны үеэр Лэндийн бүүтээр зочилсон харилцагч нарт ЛэндМН компанийн тухай болон бүтээгдэхүүнүүдийн тухай мэдээлэл өгч, LendMN-ийн зээлийн гэрээ байгуулах, нээлттэй ажлын байртай танилцах боломжийг бүрдүүлэн ажилалаа.

Энэхүү арга хэмжээгээр бизнесийн салбарын засаглал, хүний нөөцийн бодлогын талаар, хүний нөөцийн бодлогоороо Хүн төвт ирээдүй рүү чиглэж байгаа тухай сонирхолтой панел хэлэлцүүлгүүд болсон бөгөөд хамгийн сонирхолтой нь Stakeholder Economy бүтээх нь сэдвээр Ч.Анар болон Д.Энхтувшин ШАРК нар нээлттэй ярилцаа.

Ажлын байр хүндээ улам бүр ээлтэй болж буй дэлхий нийтийн чиг хандлага, технологийн дэвшил, шинэ үеийн залуучуудын хүлээлт, ковид цар тахал,

тэдгээрээс үүдэлтэй ажлын байранд гарч буй өөрчлөлт, ажил олгогчдын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шалгарсан туршлага зэргийг хуваалцах, дотоодын зах зээлд үүсээд буй хөдөлмөрийн зах зээлийн асуудал, түүний шийдлийн талаар ярилцаж ажил олгогч болон ажилтанд нээлттэйгээр 3 блок сэдвийн дор хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн салбартаа анхдагч арга хэмжээ болсон.

Арга хэмжээний үеэр цар тахлын хүнд нөхцөлд үйл ажиллагаагаараа манлайлан ажилласан, Монголын эдийн засгийн томоохон тулгуур багануудын нэг болон амжилттай ажилаж байгаа, байгууллагын удирдлагын менежмент, соёлоороо нийгэмд шинэ жишиг тогтоож буй компани, хамт олныг 14 төрөлд өрсөлдүүлэн, нээлттэй, хараат бус шүүгчдийн тусламжтайгаар шалгарууллаа.

#GWA2022 #employerbranding

#LendMN #АсааШинээрСэтгэ

#АсааАмжилтааБүтээ



New Work Summit
GOOD WORKPLACE AWARDS 2022



Бизнесийн үйл ажиллагаа

"Глобал Боловсролын Форум 2022"-д ЛэндМН оролцлоо

"Ирээдүйгээ өөрчилье" уриан дор зохион байгуулагдсан "ГЛОБАЛ БОЛОВСРОЛЫН ФОРУМ 2022"-д ЛэндМН нь боловсролд хөрөнгө оруулах, боловсролд зориулсан санхүүгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор "ОДОО СҮРЬЯ, ДАРАА ТӨЛҮЕ" уриатайгаар Lendpay үйлчилгээгээ танилцуулан оролцлоо.

Зайсан Хилл, эвент зааланд 2 өдөр үргэлжилсэн уг форумд Монгол улс даяар боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нэг дор цуглаж салбарын хөгжил, түүнээ тулгарч буй асуудал, боловсролын салбарын технологийн дэвшил, салбарын хөрөнгө оруулалтын талаар хэлэлцэн, хамтарсан бодитой шийдэл олж хэрэгжүүлэх тухай бүтээлч хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн юм.

Форумд хүрэлцэн ирж ЛэндМН-ийн бүүтээр зочилсон харилцагч нартад Lendpay үйлчилгээгээр суралцах боломжтой сургалтын төвүүдийн мэдээллийг өгөхөөс гадна, Lendpay үйлчилгээний эрхээ тогтоогдох, LendMN апликацийн зээлийн гэрээ байгуулах боломжуудыг харилцагчдадаа олгон ажиллаа.

#БоловсролыгДэмжигч #LendMN



Бизнесийн үйл ажиллагаа

"Tech Invest 2022" арга хэмжээнд оролцлоо

"Оролц, бүтээлц, хөрөнгөж" уриатай "Tech invest 2022" арга хэмжээ 6 дугаар сарын 11-нд "Zaisan hill complex"-ийн Event hall-д боллоо. Хүмүүсийн амьдралын хэв маяг технологийн хэрэглэгч байх хязгаараас тэлж хүн бүр өсөлт, хөгжлийн хөдөлгүүр нь байж эргээд ашиг хүртэн хөрөнгөжих боломжтой шинэ түүхийг "Tech invest 2022" анхны чуулга уулзалаат эхлүүлсэн юм. Тус арга хэмжээний үеэр Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагууд, технологийн салбарын хүчирхэг тоглогчид, үүсгэн байгуулагчид тус арга хэмжээнд очсон хүмүүс, телевиз үзэгчидтэй хамт хөрөнгө оруулалтын цоо шинэ түүхийг эхлүүлэн, мэдлэг мэдээлмээ солицон, үр өгөөжтэй нэг өдрийг хамтдаа өнгөрөөлөө.

Энэхүү арга хэмжээнд ЛэндМН-ийн толгой компани АНД Глобал хамтран зохион байгуулж оролцлоо. Тус арга хэмжээний үеэр ЛэндМН, АНД глобалын бүүтээр зочилсон харилцагчад LendMN апликеийшний "Хөрөнгө оруулалт" цэсний тухай мэдээлэл, зээлийн гэрээ байгуулах, АНД Глобал групп компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг өгч ажиллаа. Мөн "Tech invest 2022" арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүмүүст AND Global, LendMN-ийн хөрөнгө оруулалтын түүх болон Стартап-аас олон улсын бизнес хүртэлээ ямар замналыг туулсан, технологид хөрөнгө оруулах шалтгаануудыг нээлттэй ярилцаа.

"Tech invest 2022" технологийн салбарт өөрийн биеэр оролцон, хүчирхэг компаниудыг бүтээлцэх зорилготой, хөрөнгөжих эрмэлзэлтэй хүн бүрт зориулагдсан арга хэмжээнд "АНД глобал" группийн гүйцэтгэх захирал Б.Хос-Эрдэнэ, "Бюти секретс"-ийн гүйцэтгэх захирал, Д.Энххорвоо", "Тапатрип"-ийн гүйцэтгэх захирал З.Батгэрэл, "ОНДО"-ийн гүйцэтгэх захирал Ч.Анар, "ОНДО"-ийн Маркетингийн газрын захирал Б.Мандуул "Сэнди"-ийн ТУЗ-ийн дарга Б.Наранбат, "Райнос инвестмент"-ийн дэд захирал Н.Цэвэгмид оролцож өөрсдийн компанийн технологийг танилцуулснаас гадна хөрөнгө оруулалт компаниудад хэчинээн чухал хийгээд хөрөнгө оруулалтаасаа ямар үр ашиг хүртэх боломжтой талаар илтгэл хэлэлцүүллээ.

Түүнчлэн "Өлзий&Ко капитал ҮЦК-ийн гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр модераторын "Tech invest 2022" болон МҮОНРТ-ийн "Монголын мэдээ" сувгийн захирал Р.Гандиймаа модераторын үүргийг гүйцэтгэж "Эмэгтэйчүүд ба мөнгө" хэлэлцүүлгийг өрнүүлсэн юм.

Технологийн компаниуд зах зээлийн тоглоомын дүрмийг өөрчлөх цаг айсүй.

#TechInvest2022

Tech Invest

Powered by
ногоон
СУМ 2022





Бизнесийн үйл ажиллагаа

"Авто Машинтай Болоход Амархан" өдөрлөгт Lendauto-Эко автомашины зээлийн үйлчилгээгээр оролцлоо

Энэхүү өдөрлөг нь 2022.05.28~5.30-ны өдрүүдэд Мишээл экспогийн зүүн талд байрлах Автомарт худалдааны төвд болсон юм.

LendMN аплийкейшнээр автомашины зээлийн эрх үүссэн бол "Авто Машинтай Болоход Амархан" өдөрлөгт хүрэлцэн ирээд автомашинтай болох боломжийг харилцагч нартаа олгон автомашины

зээлийн асуудлыг өдөрт нь шийдэж ажилалаа.

Эко автомашины зээлийг LendMN-ээс...

Урьдчилгаа: 15%

Хугацаа: 48 сар хүртэл

Зээлийн хүү: 2.3%-2.6%

#АжлааAmжуул



Бизнесийн үйл ажиллагаа

Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын нэрэмжит "Цэцэрлэгт Хүрээлэн"-ийн шав тавих их үйлсэд нэгдэж, ЛэндMN-ийн хамт олноороо Гачууртын Минж үржүүлгийн газарт мод тарилаа.

ЛэндMN нь ногоон ирээдүй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтод ажлуудад нийгмийн хариуцлагынхаа хүрээнд идэвх чармайлттай оролцохыг зорьж ажиллаж байгаа билээ.

Үүний хүрээнд бид Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын нэрэмжит "ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН"-ийн шав тавих их үйлсэд нэгдэж хамт олноороо Гачууртын Минж үржүүлгийн

газарт мод тарилаа.

Энэхүү их үйлсэд хамт олон, гэр бүлээрээ оролцон хамтдаа модоо тарьсан нийт ББСБ-үүдийн хөдөлмөрч залуусдаа талархал илэрхийлье.

#НогоонИрээдүйдЗориулья #LendMN



Бизнесийн үйл ажиллагаа

ЛэндМН-ийн залуучууд Чингэлтэй дүүргийн Хайрхан Хөгжлийн Төвд 150 ширхэг мод тарилаа.



ЛэндМН нийгмийн хариуцлагынхаа хүрээнд байгаль орчноо хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор өөрсдийн төгөлтэй болох их үйлсийг ийнхүү эхлүүлээд байна.

Мод тарих үйл ажиллагааг Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар болон Ургуулахад учир бий клубтэй хамtran Чингэлтэй дүүргийн Хайрхан Хөгжлийн Төвд 150 ширхэг мод тарилаа.

ЛэндМН нь энэхүү үйл ажиллагаагаа цаашид харилцагч хэрэглэгчдийн оролцоотойгоор улам өргөжүүлж байгальд ээлтэй хамт олон болохоор зорин ажиллаж байна.

#НогоонИрээдүйгДэмжигчЛэндМН





А.Мөнхбаяр нар нийт баг тамирчиддаа амжилт хүсэж, төрийн дуулал эгшиглэн тэмцээнийг нээсэн. Нээлтийн үеэр ББСБ-үүд хамтарсан "We Care Tomorrow" уриаг илэрхийлсэн мэндчилгээ нь биднийг зорилго нэгтэйг илтгэж чадсан.

"Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо" "ЛэндМН ББСБ" ХК хамтран зохион байгуулсан Сагсан Бөмбөгийн Аварга Шалгаруулах 8 Дахь Удаагийн "We Care Tomorrow" уриатай ТЭМЦЭЭН 2022.05.14-15 өдрийн хооронд амжилттай зохион байгуулагдаж, нөхөрсөг гал гарсан өрсөлдөөнтэй, сонирхолтой, тогтолтуудаар дүүрэн болж аваргуудаа шалгарууллаа.



Бизнесийн үйл ажиллагаа

"We Care Tomorrow" уриатай Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны "Сагсан Бөмбөгийн Аварга Шалгаруулах 8 Дахь Удаагийн Тэмцээн"-ийг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү тэмцээн нь МББСБХолбооны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулгасанаараа онцлог байлаа.

Тэмцээний нээлтээр Монголын банк бус санхүүгийн байгууллагудын ерөнхийлөгч

З.Алтанзул, Санхүүгийн зохицуулах хорооны

банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга

Б.Итгэлсүрэн, "ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх

захирал Б.Удвал, Монголын банк бус санхүүгийн

байгууллагудын холбооны гүйцэтгэх захирал




Эрэгтэй сагсан бөмбөгийн тэмцээнд:

- 1 байрт Соно Финтек ББСБ ХХК
 - 2 байрт Нэт Капитал Финанс Корпораци ББСБ ХХК
 - 3 байрт Транскапитал ББСБ ХХК
- Эрэгтэй шилдэг тоглогчоор /MVP/ Соно Финтек ББСБ ХХК-ийн Э.Хосбаяр тодорлоо.

Эмэгтэй сагсан бөмбөгийн тэмцээнд:

- 1 байрт Бичил Глобус Финанс ББСБ ХХК
- 2 байрт Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК

■ 3 байрт Есөн Шижир Инвест ББСБ ХХК
 Эмэгтэй шилдэг тоглогчоор /MVP/ Бичил Глобус ББСБ ХХК-ийн Д.Нансал тодорлоо.
 Нийлбэр дүнгээр тэргүүн байр шилжих явах цомын эзнээр Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК тодорлоо.
 Тэмцээнд амжилттай оролцож, хурд хүч авхаалж самбаагаа дайчлан нөхөрсөгөөр өрсөлдсөн нийт ББСБ-үүдээ спортын болон ажлын өндөр амжилт хүсье.
 #WeCareTomorrow



Бизнесийн үйл ажиллагаа

2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр арилжаалсан “ЛэндБонд Транч-1”-ийн өгөөж 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр үнэт цаасны дансанд байршилаа.

Харилцагч та “ЛэндБонд Транч-1”-ын өгөөжөө
өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн 7510-0575
дугаарт хандаарай.

Хэрвээ та SuperUp апликешион ээр “ЛэндБонд
Транч-1” захиалан авсан бол Rhinos Investment

UTsK LLC үнэт цаасны компанийн 7510-0575
дугаарт хандаарай.

#ДижиталХөрөнгөОруулалт #ЛэндБонд
#СанхүүгээЗөвУдирддагХүнБүртЗориулав



Бизнесийн үйл ажиллагаа

**Lendзээл-Хэрэглээний
зээлийг LendMN-ээс...
маркетингийн компанийт
ажлыг амжилттай
явууллаа.**

Та Гар утасныхаа ганцхан товчийг дарж 2 сая
хүртэлх төгрөгийг хэрэглээндээ зориулаад Хэзээ
ч, Ханаас ч, зээлээрэй.

#АсааАсуудлааШийд #LendMN



Бизнесийн үйл ажиллагаа

"Асаа Азаа Үз" урамшуулалт хөтөлбөр заралаа

"Асаа Азаа Үз" урамшуулалт хөтөлбөрийг 2022.05.01-2022.05.27 хооронд зарлаж амжилттай явууллаа.

LendMN аппли케йшний үнэнч харилцагчдадаа зориулан дээрх хугацаанд LendMN аппликеийшнээ шинээр татсан, зээлийн гэрээгээ шинээр байгуулсан, зээлээ сунгасан дээрх 3 нөхцөлийн аль нэгийг нь биелүүлээд л урамшуулалт хөтөлбөрт оролцох боломжийг бурдүүлэн ажилалаа.

Урамшуулалт хөтөлбөрийн үргэлжилсэн 3 долоо

хоногийн хугацаанд нийт 15 азтаныг бүртгэлтэй утасны дугаараар нь LendMN facebook хуудсаар 3 удаагийн Live хийж тодруулан, LendMN-ийн шинэ үйлчилгээ Lendpay үйлчилгээтэй хамтран ажилмагч байгууллагуудын гоёмсог, чамин бэлгүүдийг бэлэглэж урамшууллаа.

#AcaaAzaaYz #LendMN

#AcaaAcsudlaashiyd



Бизнесийн үйл ажиллагаа

Lendauto-Эко автомашины зээл

2022 оны 2 дугаар улиралд


автомашины зээлийн үйлчилгээнд орсон томоохон өөрчлөлт нь зээлийн эрхийн дээд хэмжээг 30 сая болгож шинээр Toyota Sai машин нэмэгдсэн явдал байлаа.

Аппликеийшн дээр автомашины зээлийн цэс App 2.0-ийн стандартын дагуу шинэчлэгдлээ.

Зээлийн эрхийн дээд хэмжээ нэмэгдсэн, мөн маркетингийн идэвхжүүлэлт идэвхтэй хийгдсэнд үр дүнд 2 дугаар улиралд зээл олголт өмнөх улираас 5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Автомашины зээлийн эрхээ LendMN аппликеийшнээр тодорхойлж ганцхан өдрийн дотор автомашинтай болгох боломжийг олгож харилцагчдын цаг хугацааг хэмнэж, түргэн шуурхай үйлчилсэн нь хамгийн том давуу тал болж өглөө.

#AjlaaAmjuul



Харилцагчийн үйл ажиллагаа

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 20 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусlamж үйлчилгээг үзүүлэн 2022 оны II улирлын турш нийт 264,590 үдаагийн зээлийн үйлчилгээ, апликеишн ашиглалт болон бусад үйлчилгээний

талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 96.76%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

Харилцагчийн үйлчилгээ

2022 оны II улиралд хүлээн авсан
225,623
нийт дуудлага

15 секунд
хүлээлгийн түвшин

Үйлчилгээ
96.76%
амжилттай хүргэсэн

Сошиал суваг болон
38,967
үйлчилгээний заалаар үйлчилсэн



Санхүүгийн үйл ажиллагаа

2022 оны II улирлын гол үзүүлэлтүүд

Нийт актив
46.40
тэрбум төгрөг

Нийт орлого
8.1
тэрбум төгрөг

Цэвэр ашиг
1.7
тэрбум төгрөг

Цэвэр зээлийн багц
41.44
тэрбум төгрөг

Санхүүгийн байдлын хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2022 оны II улирлын байдаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 46.40 тэрбум төгрөг байгаагас цэвэр зээлийн багц 41.44 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 2.02 тэрбум

төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 23.16 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 23.23 тэрбум төгрөг байгаагас хуримтлагдсан ашиг 11.91 тэрбум төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2022.I /Аудитлагдаагүй/	2022.II /Аудитлагдаагүй/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.70	2.02
Зээлийн багц (цэвэр)	32.97	41.44
Бусад хөрөнгө	1.81	1.77
Үндсэн хөрөнгө	0.82	0.74
Биет бус хөрөнгө	0.44	0.42
Нийт хөрөнгө	40.74	46.40

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2022.I /Аудитлагдаагүй/	2022.II /Аудитлагдаагүй/
Өр төлбөр	18.28	23.16
Эх үүсвэр	15.31	20.37
Бусад өглөг	2.97	2.79
Эздийн өмчийн дүн	22.46	23.23
Хувьцаат капитал	8.48	8.48
Хоёрдогч өглөг	2.85	2.85
Хуримтлагдсан ашиг	11.14	11.91
Нийт өр төлбөр болон эздийн өмч	40.74	46.40



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2022 оны II улирлын байдлаар компанийн нийт орлогын хэмжээ 8.1 тэрбум төгрөг, өссөн дүнгээр 1.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2022.I /Аудитлагдаагүй/	2022.II /Аудитлагдаагүй/
Нийт орлого	3.80	4.35
Хүүгийн зардал	(0.85)	(0.95)
Цэвэр орлого	2.95	3.40
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.35)	(0.49)
Үйл ажиллагааны цэвэр орлого	2.60	2.91
Удирдлагын болон YA-ны зардал	(1.55)	(2.02)
Татварын өмнөх ашиг	1.05	0.89
Татварын зардал	(0.12)	(0.12)
Цэвэр ашиг	0.93	0.77

Шимтгэлийн орлого (тэрбум төгрөг)



Цэвэр ашиг өссөн дүнгээр (тэрбум төгрөг)



Эрсдэлийн удирдлага



“ЛэндМН ББСБ” ХК нь зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн мөрдөн ажилмаж байгаа төдийгүй харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанийд ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажилласаар байна.

2022 оны II улиралд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг тус журамтай нийцүүлэн шинэчлэн баталлаа.

2022 он гарснаас хойш салбарын хууль, журам ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуултыг хагас жил тутамд СЗХ-руу тайлагнах үүргээ биелүүллээ.

Мөн 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгуулагын зээлийн үйл ажиллагааны журам” батлагдсантай холбоотойгоор компанийн “Зээлийн үйл ажиллагааны журам”-ыг тус журамтай нийцүүлэн шинэчлэн баталлаа.

2022 он гарснаас хойш салбарын хууль, журам

шинэчлэн гарч байгаатай холбоотойгоор тухай бүр холбогдох дотоод журмууддаа цаг алдалгүй нийцүүлэн, үйл ажиллагаандaa хэрэгжүүлж байна. “ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2022 оны II улиралд 1.63 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан

байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.03 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 114.2%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. 2022 оны II улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Зохистой харьцааны шалгур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2022.I	2022.II
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	46.48%	41.55%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	53.22%	47.35%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	48.16%	43.95%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	25.75%	8.71%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-11.00%	-9.97%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	35.54%	37.11%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	32.62%	44.52%

Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ”ХК нь компанийн сайн засаглалын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдээс урт хугацааны үнэ цэнийг бий болгох, нэмэгдүүлэх, компанид итгэх итгэлийг бэхжүүлэн ажиллахыг эрмэлзэг төдийгүй Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагнал, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг

дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримталж, сайн засаглалын хэм хэмжээ, стандартыг бүрдүүлж ажилладаг.

Манай компани нь 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг дотоод үйл ажиллагаандаа мөрдөн ажилмаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) нь 2022 оны II улиралд ээлжит I, ээлжит бус I удаа хуралдav. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлуудаас онцлон дурдав:

- 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдөр болсон Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн ердийн 3 гишүүн, хараат бус I гишүүнийг шинээр, ТУЗ-ийн ердийн 3, хараат бус 2 гишүүнийг тус тус улируулан сонгосон билээ. Ийнхүү компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон ТУЗ нь 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдаж, ТУЗ-ийн даргаар О.Болдбаатарыг улируулан сонгосон ба ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Б.Оюунболдыг томилов.
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд болон даргыг сонгосон бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дараах бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна:

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Б.Итгэл, гишүүдээр С.Энх-Амгалан, В.Баярсайхан, Д.Галхүү, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ нар ажилмаж байгаа бол ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар Ж.Жаргалсүрэн, гишүүдээр С.Боргил, О.Болдбаатар харин ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны даргаар С.Энх-Амгалан, гишүүдээр С.Боргил, Д.Галхүү нар сонгогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын гарсан шийдвэрээс дурдавал:

- Компанийн эх үүсвэрийг үр ашигтай удирдах зорилгоор “Мони Маркет Фанд” ХХК-ийн удирдан явуулж буй мөнгөний захын оролцогч болох, улмаар репо арилжаанд оролцох эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
- “АНД Системс” ХХК-тай байгуулсан Менежментийн үйлчилгээний гэрээг анх байгуулсан үндсэн нөхцөлөөр цааш сунгахаар шийдвэрлэж, гэрээний хугацаанд зах зээлийн дунджаас харьцангуй хямд үнээр, чанартай үйлчилгээг авахаар болов.
- Компанийн бизнесийн өсөлт хөгжил, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулах, компанийн үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах, хүний нөөцийг үр дүнтэй хуваарилж, ашиглах зорилгоор компанийн бүтцийг ТУЗ-өөс баталсан 2022 оны төсөвт нийцүүлэн тухай бүр өөрчлөлт оруулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
- Компанийн онцгой эрхтэйгээр ашиглаж буй LendMN 2.0 программ хангамжийг хөгжүүлэгч, технологийн түнш байгууллага “АНД Сольюшнс ПТИ. ЛТД”-д тус applicейшны зарим функциудыг Core banking system болон UaaS solution программ хангамжуудад ашиглах эрхийг олгож, цаашид Core banking system болон UaaS solution программ хангамжуудаас LendMN 2.0 программ хангамжид хэрэг болохуйц функциудыг үнэ төлбөргүй ашиглахаар шийдвэрлэв.
- Компанийн эрхлэн явуулж буй “Lendpay” үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, боловсролын салбарт ажилмаж буй байгуулмагуудтай хамтран ажиллах зорилгоор “Томё ЭдТек” ХХК-тай “Lendpay” үйлчилгээнд хамтран ажиллах гэрээ” байгуулахаар шийдвэрлэв.
- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримтыг шинэчилж, Монгол Улсад төдийгүй олон улсад шинээр ашиглагдаж буй стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэхээр болов.

ТУЗ нь 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр эчнээ санал

хураалтаар дор дурдсан шийдвэрийг гаргав:

- “ЛэндМН ББСБ” ХК-ийн хэвийн зээлийн багцаас худалдан авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани байгуулж, охин компани нь “ЛэндМН ББСБ” ХК-ийн үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх үндсэн чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2022 оны II улиралд I удаа буюу 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр хураldav.

ТУЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо:

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:

- Гүйцэтгэх удирдлагын 2022 оны цалин урамшуулал.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо:

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:

- Компанийн эрсдэлийн тайлан
- Эх үүсвэрийн тайлан

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо:

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:

- Дотоод аудиторын дэлгэрэнгүй тайлан.





ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn